

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2013 оны 2 дугаар сарын 21

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2013 оны 01 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012-12 сар	/тоогоор/	
			Нэмэгдсэн	Хасагдсан
1	Даатгалын компани	18	1 ¹	17
2	Даатгалын компанийн салбар	213		213
3	Даатгалын төлөөлөгч	2357	34 ²	2391
4	Даатгалын зуучлагч	17		17
5	Даатгалын хохирол үнэлэгч	9	1 ³	10
6	Актуарч	15		15
7	Бусад	15		15

¹ Хорооны 2013 оны 01 дүгээр сарын 09 -ний өдрийн 14 дүгээр тогтоолоор “Жонон даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан байна.

² Хорооны даргын 2013 оны 01 дүгээр сарын 23 -ны өдрийн 19 дүгээр тушаалаар “Номин даатгал” ХХК-ийн 14 иргэнд, Хорооны даргын 2013 оны 01 дүгээр сарын 11 -ний өдрийн 08 дугаар тушаалаар “Монгол даатгал” ХХК-ийн 15 иргэнд, “Ард даатгал” ХХК-ийн 5 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

³ Хорооны 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 28 дугаар тогтоолоор “Ашид билгүүн” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2013 оны 01 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2012.01.31	2013.01.31
Даатгалын нийт хураамж	3,655,134,785.53	4,521,365,043.14
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	332,507,006.18	418,535,367.75
Олгосон нийт нөхөн төлбөр	923,860,021.85	2,672,877,568.51

Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	11,177,915.00	1,300,431,155.80
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	13.00	2,619.00
Давхар даатгалд төлсөн хураамж	588,437,465.12	742,478,370.63
Байгуулсан даатгалын гэрээний тоо	17,340.00	14,285.00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	7,201.00	7,380.00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	9,967.00	7,931.00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	23,548,694,400.00	139,261,000,000.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	43,318,033.00	70,876,858.74

2013 оны 01 дүгээр сарын байдлаар даатгалын хураамжийн орлого 2012 оны мөн үеийнхээс 866.3 сая төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 86.0 сая төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн байна.

2013 оны 01 дүгээр сарын байдлаар даатгалын нөхөн төлбөр 2012 оны мөн үеэс 1749.0 сая төгрөгөөр буюу 2.9 дахин өссөн. Жолоочийн албан журмын даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеэс 116.3 дахин өссөн байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
	2012.01.31 /сарын дүн/	2013.01.31 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	29,534,576.20	20,571,701.00
Олгосон нийт нөхөн төлбөр	18,092,625.00	3,218,258.00
Давхар даатгалд төлсөн хураамж	5,325,200.00	550,000.00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	11.00	20.00
Хувь хүний хугацаат даатгалд	2.00	3.00
Байгууллагын хугацаат даатгалд	0.00	1.00
Өндөр хамгаалалттай ЭМД-д	0.00	
Эмнэлгийн мөнгөний даатгалд	2.00	5.00
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	3.00	2.00
Тэтгэврийн даатгалд	4.00	4.00
Орон сууцны даатгалд	0.00	2.00
Хуримтлалын даатгалд	0.00	2.00
Зээлдэгчийн амь насны даатгалд	0.00	1.00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	1.00	
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	400,000,000.00	40,000,000.00

Урт хугацааны даатгагчийн даатгалын хураамжийн орлого 2013 оны 01 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 9.0 сая төгрөгөөр буурч, мөн даатгалын нөхөн төлбөр мөн үеийнхээс 5.7 дахин буюу 14.8 сая төгрөгөөр буурсан байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

Үзүүлэлт	2012.01.31 /сарын дүн/	2013.01.31 /өссөн дүн/
Нийт орлого	78,603,917.61	29,530,573.77
Даатгалын зуучлагчийн орлого		25,815,089.30
Үүнээс: Сайн дурын даатгал		20,772,743.00
Албан журмын даатгал		603,699.30
Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	54,388,033.00	43,849,358.42
Зуучилсан даатгалын гэрээний тоо	53.00	41.00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	25,546,462,808.00	33,495,360,000.00

2013 оны 01дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 25.8 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Хаан банк” ХХК, “Пийс оф лайф” ХХК, “Жомолхари” ХХК, “Нэйшнл эженси” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Изи инвестмэнт” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Си эн эн икс” ХХК, “Хасбанк” ХХК-иуд тус тус 01 дүгээр сарын мэдээг ирүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

Үзүүлэлт	2012.01.31	2012.01.31
Нийт орлого		40,740,688.00
Даатгалын хохирол үнэлсэний орлого	10,013,072.00	23,722,324.00
Үүнээс: Сайн дурын даатгал		15,198,006.00
Албан журмын даатгал		8,524,318.00
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	509.00	1,822
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	88,020,000.00	157,682,918.00

2013 оны 01 дүгээр сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 23.7 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх оны мөн үеэс 13.7 сая төгрөгөөр өссөн байна.

“Мега марз” ХХК, “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК-иуд тус тус 01 дүгээр сарын мэдээг ирүүлээгүй байна.

БУСАД

Хорооны 2013 оны 01 үдээр сарын 23-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” шийдвэрийг гаргасан байна.

ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС